

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1-р сарын 06-ны өдөр цахимаар хуралдаж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2-р хуралдааныг 1 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж Хороодын үйл ажиллагааг дэмжих тухай, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар уламжлах тухай, “Хүн амын эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дэд зөвлөл байгуулж, дүрэм батлах тухай, аймгийн ИТХ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

1-р сарын 13-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөл хуралдаж хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүн, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн биелэлтийн тайланг сонсож, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөн “Аймгийн аварга малчин өрх”, “Аймгийн аварга саальчин”, “Аймгийн аварга фермер”, “Аймгийн аварга тариаланч, тариаланч хамт олныг шалгаруулах” журмыг шинэчлэн батлуулахаар Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс журмын төслийг танилцуулж, зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг тусган, сумдад хүргүүлэхээр боллоо.

2021 оны 1-р сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөн болж, аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал, Засаг дарга Д.Золжаргал нар оролцож, зөвлөгөөнийг аймгийн Засаг дарга Д.Золжаргал нээж, аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын дарга нар мэдээлэл хийв.

Мөн энэ үеэр агентлагуудын 2020 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг танилцуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр эхний 5 байрт орсон байгууллагуудад Өргөмжлөл гардуулж, хэлтэс, агентлаг, байгууллагын дарга нарт аймгийн Засаг дарга 11 төрлийн үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг удирдах ажилтнуудад үүрэг болголоо.

Мөн өдөр аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга, төсөвт байгууллагын дарга нартай онлайн хурал зохион байгуулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар Ковид-19 цар тахлын үед зарим сумдад ажилласан хяналт шалгалтын явцын талаарх мэдээлэл, анхаарах асуудлыг хэлэлцэж, зөрчил илэрсэн зарим сумдад албан шаардлага хүргүүлэх талаар мэдээлэл хийж, сумын 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, эхний 5 суманд орсон сумдыг шагнаж шийдвэрийг ХШҮДАХ-ийн дарга танилцуулж, аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт 15 чиглэлийн хугацаатай үүрэг даалгавар өгсөн байна.

2021 оны 1-р сарын 29-ний өдөр аймгийн Засаг даргын зөвлөл хуралдаж Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг сонсож, ЗГХЭГ-т тайланг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудын согтууруулах ундаагаар үйлчлэх худалдах цагийн хязгаарыг 1 дүгээр сарын 30-наас 2 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд 10:00 цагаас 15:00 цаг хүртэл байхаар тогтоосон байна.

Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 137 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/927 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээнд Шуурхай штаб, хариу арга хэмжээний 10 багийг 148 хүний

бүрэлдэхүүнтэй байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж орон нутгийн чанартай авто замын хөдөлгөөнд 2 пост гарган, 150 гаруй алба хаагч, 15 техник хэрэгсэлтэйгээр аймаг, сумаас гарах, орох тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнд хяналт тавьж, зайлшгүй шаардлагатай 13А маягт, буяны үйл ажиллагаанд оролцох, мах, түлээ, хүнсний ачаа тээвэр хийх болон аймаг, сум хооронд асуумжаар явж байгаа нийт 1100 гаруй иргэдэд зөвшөөрөл өгч ажиллалаа.

Улаанбаатар хотоос аймгийн иргэдээ татан авах ажлыг аймгийн Онцгой комисс хуралдан шийдвэрлэж ажлыг хэсгийг томилон 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 30-ны өдрийн хугацаанд татан авахаар төлөвлөн бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн Архангай аймагт коронавирус /ковид-19/ цар тахалын халдвар орж ирэх эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийж холбогдох зөвлөмжийг шуурхай штабын дарга, менежер нарт танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

2021 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт 105.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 110.0 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 104.1 хувиар, аймгийн төсөвт 553.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 542.9 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 98.2 хувиар тус тус биелүүлэхээр ажиллаж байна.

Цахимаар татвар төлөх талаар видео бичлэг, татварын тайлан хүргүүлэх хугацаа, татварын хууль тогтоомжтой холбоотой 5 мэдээллийг аймгийн Татварын хэлтсийн пэйж хуудсанд 2-3 удаагийн давтамжтайгаар байршуулан, 217 хүн үзэж, 203 хүн шейр хийж, бусдад түгээсэн байна.

Хөрөнгө оруулалт

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

Орон нутгийн өмч

Сумдын төсөвт байгууллагууд, ОНӨГ-ын 2020 оны худалдан авалтын тайлан, 2020 оны сумдын худалдан авалтын төлөвлөгөөг нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлээ. 1-р сард улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 4, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 1, нийт 5 тендер зарлагдсан.

Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын 2020 оны үндсэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийн тайланг хүлээн авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэхээр нэгтгэж байна.

Санхүүгийн хяналт

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд урд оноос шилжин төлөвлөгдсөн аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Орон нутгийн өмчийн газарт хяналт шалгалт хийгдэж байна. Мөн хугацаанд аймгийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн хүрээнд 1 сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгсний зэрэгцээ улсын ахлах байцаагчийн 4 төрлийн актаар 4.0 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоогдож, ажилтан албан хаагчдад нөхөн олгуулах, төсөвт төлүүлэхээр шийдвэрлэлээ.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

2021 оны 1-р сард Онцгой байдлын газарт гамшиг осол, аюулт үзэгдлийн 9 дуудлага хүлээн авснаас объектын гал түймрийн дуудлага 7, эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага 1, зам тээврийн ослын дуудлаг 1 тус тус хүлээн авч ажилласан байна.

Онцгой байдлын газраас шинэ жилийн баяр болж буйтай холбогдуулан олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийг болзошгүй аюулаас коронавирус /ковид-19/

цар тахлаас урьдчилан сэргийлэх, амны хаалтаа тогтмол зүүх, хүн хоорондын зай хэмжээг баримтлах зорилгоор Архангай аймгийн Онцгой байдлын газраас нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээний хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 31-ны 10:00-18:00 цагт “Гост”, “Тансаг” “Тэрх”, “Хасу” нийтийн худалдааны төвийн ажилчид, үйлчлүүлэгчид, ард иргэдийг хамруулан өдөрлөг арга хэмжээ зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр ард иргэдэд “Аюулгүй өрх” гарын авлага, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх санамж гарын авлага 360 ширхэгийг тарааж, автомашин болон худалдааны төвийн чанга яригчаар ахуйн гал түймэр, коронавирус /ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх шторк сэрэмжлүүлгийг ард иргэдэд хүргэлээ.

Засгийн газрын 2020 оны 209 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/897, 2021 оны А/08 дугаар захирамжуудын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2021 он гарснаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, фитнес, зочид буудал зэрэг 116 байгууллага, аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ.

Дээрх хяналт шалгалтын хүрээнд нийт 172 зөрчлийг илрүүлж 102 зөрчлийг / хүн хоорондын зай баримтлан суулгах ширээ, сандалыг цөөлөөгүй, хэрээс хориглосон тэмдэг, зай барих тэмдэг тэмдэглэгээг хийгээгүй, гар ариутгалын бодис, халуун хэмжигчийг байрлуулаагүй/ газар дээр нь арилгууллаа. Нийт зөрчлийн 48.0 % нь 2 цаг тутам цэвэрлэгээ, үйлчилгээ хийж бүртгэл хөтөлдөггүй, хүн хоорондын зай барих, тэмдэг тэмдэглэгээгүй, үйлчлүүлэгчийн халуун хэмжээгүй, QR кодыг байршуулаагүй зөрчил эзэлж байна. Мөн аж ахуй нэгж, байгууллагын гадна орчны 50 м хүртэлх газрын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэдэггүй зөрчил 20 %, өдөр тутам дотоод цэвэрлэгээ, ариутгалыг хийж хэвшүүлээгүй, ажилтан, албан хаагчдын биеийн дулааныг хэмжих бүртгэл хөтлөөгүй зөрчил нь 32 % -ийг тус тус эзэлж байна. Нийтийн хоол үйлдвэрлэл, фитнесийн газруудад халдваргүйжүүлэлт бүрэн хийлгэж, QR кодоо байршуулах талаар зөвлөмжийг өгч байна. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт улсын байцаагчийн 17 заалт бүхий 31 зөвлөмж, фитнесийн үйл ажиллагаа эрхлэгчдэд 13 заалт бүхий 3 зөвлөмж, зочид буудлын үйлчилгээ эрхлэгчдэд 14 заалт бүхий 13, нийт 82 мэдэгдэл, зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна.

2020 оны 12-р сард аймгийн хэмжээнд 435 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 134, хулгайлах гэмт хэрэг 172, иргэдийн өмчийн гэмт хэрэг 61, малын хулгайн гэмт хэрэг 102, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 31, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 123, гэмт хэргийн илрүүлэлт 55.0 хувьтай байна.

Нийт 27431 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 26621 иргэнд 900.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1645.5 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 49.1 хувьтай байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулалтын зөвлөл 1-р сарын 21-ны өдөр хуралдаж, аж ахуй нэгж-5 / бүтээгдэхүүн-2 /, Худалдааны газар, Иргэн-23 / дэн буудал-1, хоолны газар-1, нийт 28 үйлчилгээний газрын тохирлын гэрчилгээг сунгасан байна.

Шүүхийн шинжилгээний алба 1-р сард криминалистикийн шинжилгээ 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 19, шүүх эмнэлгийн шинжилгээ, тусгай 30 шинжилгээ хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс 1-р сард дараах бүртгэлийг хийсэн байна.

Иргэний бүртгэл чиглэлээр:

- Төрсний бүртгэл – 157
- Гэрлэсний бүртгэл - 178
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-6
- Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 13
- Үрчилсний бүртгэл - 3
- Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл – 21
- Нас барсны бүртгэл - 40
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 149

Хамгаалах хувцас өмсөх тайлах онолын сургалтад нийт 589 эмнэлгийн ажилтан хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллага тус бүр сургалтад холбогдох эмч мэргэжилтэн, ажилтануудыг хамруулан, хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах дадлага сургуурилалтыг 20-оос доошгүй хийлгэн дадлагажуулсан.

Коронавирусын халдварын вакциныг эрүүл мэндийн салбарын нийт 1308 хүнд хийлгэхээр ажилтануудын мэдээлэл судалгааг гарган ХӨСҮТ-д хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/07 дугаар захирамжийн дагуу 15 сумдын Эрүүл мэндийн төвийн коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд явцын хяналт хийж, тайлан бичиж, тус сумдад зөвлөмж хүргүүлэв.

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгслийн 2021 оны тендерийн багцад захиалгыг 32 багцын 390547422 төгрөгөөр боловсруулан Өмчийн газарт хүргүүлсэн.

Түргэвчилсэн шинжилгээнд нийт 3147 хүнийг хамруулж, бүгд сөрөг гарсан. Улаанбаатараас ирсэн нийт 1380 иргэнийг гэрийн ажиглалтанд хянаж, зөвлөмж өгсөн.

Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт зэрэг нийт 5 суманд өвөлжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, КОВИД-19 ийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах, өвчлөл бүртгэгдсэн нутгаас ирсэн иргэдийг гэрт нь тусгаарлан ажиглах 14 хоногийг зохион байгуулсан байдал, бүртгэл, тандалтын хуудас зэрэгтэй газар дээр нь танилцан холбогдох зөвлөмж, үүрэг чиглэл өгсөн.

Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааны бэлтгэл ханган холбогдох бүртгэл судалгааг гарган ХӨСҮТ-д хүргүүлсэн. Үүнд: Дархлаажуулах үйл ажиллагаанд оролцох болон нэмэлтээр дайчлагдах эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа нийт эмнэлгийн ажилтан, архаг хууч өвчинтэй, хөгжлийн бэрхшээлтэй, 50 ба түүнээс дээш насны иргэд, орон гэргүй зорилтот бүлгийн иргэд, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургууль, МСҮТ-ын багш ажилчид, эрчим хүч, усан хангамжийн байгууллагын ажилчдын судалгааг гарган ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албанд хүргүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

Нийгмийн даатгалын санд 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 23,1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 123 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 18,0 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 65,2 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1173,5 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Архангай аймаг 2020 онд 5.399.530 толгой мал тоолуулж улсын хэмжээнд 2-р байрт орсон байна. 2020 онд тоолуулсан малын тоог өмнөх онтой харьцуулбал 767.506 толгой мал буюу 12,4 хувиар буурсан, малын тоог төрлөөр нь авч үзвэл Адуу- 387748, Тэмээ- 1286, Үхэр- 679921, Хонь- 2842331, Ямаа- 1489244 мянган толгой мал тус тус тоолуулсан байна. Малыг өмнөх онтой харьцуулбал адуу – 9.0 %, тэмээ- 5.6 %, үхэр- 4.4 %, хонь- 14,4 %, ямаа- 12,8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд малын төрлөөр манай аймаг 387.7 мянган толгой адуу, 378.9 мянган толгой үхэр, 2841.9 мянган толгой хонь тоолуулж 1-р байр эзэлсэн байна.

Аймгийн хэмжээнд Эрдэнэмандал сум 468931 толгой мал тоолуулж 1-р байр, Батцэнгэл сум 406398 толгой мал тоолуулж 2-р байр, Хайрхан сум 368271 толгой мал тоолуулж 3-р байрт орсон байна.

2021 оны 1-р сарын 10-ны байдлаар гаргасан зудын эрсдэлийн зургаас үзвэл аймгийн нийт нутгийн 20 хувь гаруй хувьд нь нэн их эрсдэлтэй, 65 гаруй хувь нь их эрсдэлтэй, 10 орчим хувь нь дунд эрсдэлтэй гарсан байна. Үүнээс Цахир, Хотонт, Өлзийт сумдын ихэнх нутаг нэн их эрсдэлтэй, Тариат, Хангай, Цэцэрлэг, Хайрхан, Өндөр-Улаан, Батцэнгэл, Ихтамир, Чулуут, Өлзийт, Булган, Цэнхэр, Төвшрүүлэх, Өгийнуур, Хашаат сумууд их эрсдэлтэйд тус тус хамрагдсан байна.

Аймгийн хэмжээнд энэ онд 5399530 толгой мал өвөлжиж байна. Архангай аймагт 5 аймгийн 40-д сумаас 303 өрхийн 200 орчим мянган толгой мал отроор өвөлжиж байна. Үүнээс Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3 сумын 709 малчин өрхийн 73.2 мянган толгой мал, аймаг, орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц нутагт 2 сумын 71 малчин өрхийн 31.5 мянган толгой мал, Дорнод, Сүхбаатар, Төв, Булган, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын Гачуурт, 61-н гарамд 104 малчин өрхийн 44,9 мянган толгой мал отроор өвөлжиж байна. Баянхонгор аймгийн 19 сумаас манай аймгийн 13 суманд 169 өрхийн 59.7 мянган толгой мал, Өвөрхангай аймгаас манай аймгийн 12 суманд 91 өрхийн 38 мянган толгой мал, Завхан, Хөвсгөл, Булган аймгуудын нутгаас 43 малчин өрхийн 15.7 мянган толгой мал үүнээс манай аймгийн зарим сумдын нутагт отроор өвөлжиж байна. Бусад малчдын хувьд сум орон нутагтаа отор нүүдэл хийн өвөлжиж байна.

Малчид өөрийн аймгийн болон Төв, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс зэрэг аймгуудын нутгаас малчдын түвшинд 51.4 мянган тн өвс, 8317 тн ногоон тэжээл, 1009 тн гар тэжээл, 12 тн үйлдвэрийн тэжээл, 579.6 тн давс хужир шүүг нөөцлөн авсан. Тэжээл бэлтгэл 66 орчим хувь байсанаас 11 сарын дундаас мал нэмэгдэл тэжээлд орсон. Нийт тэжээлийн 80 гаран хувийг малчид малдаа хэрэглэсэн байна. Сумдын нөөц бүрдүүлэлт өвс 1328 тн, тэжээл 261 тн байснаас 50-60 хувийг малчдадаа зарж борлуулсан. Одоогоор сумдын нөөцөд 562 тн өвс, 173 тн тэжээл байна. Энэ онд Засгийн газрын 19 дүгээр тогтоолын дагуу аймгийн аюулгүй нөөцөд 325 тн өвс нөөцөлснөөс нөөцөд 80 орчим тн өвс байна. 2021 оны 01 дүгээр сарын 01-13-ны байдлаар 14 суманд бод 3993, бог 11493 толгой буюу нийт 15486 толгой мал хорогдсон байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын Хөдөө аж ахуйн байгууллага Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран хэрэгжүүлж буй Зорилтот бүлгийн малчин өрхийн амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төслийн хүрээнд Батцэнгэл, Өгийнуур, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал, Хотонт, Хашаат сумдын зорилтот бүлгийн хонин толгойд шилжүүлснээр 60-300 малтай, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй нийт 112 өрхөд /нэг сумын 16 өрх/ тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг 1-р сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тусламжийн багцад хорголжин тэжээл, рапсын шахдас, “Амин тун”, “Барагшуунт” сувиллын бэлдмэл, шархны тос, нүдний тос, хурганы уут, малчдад өгөх зөвлөмж, 5000 төгрөгийн нэгж багтсан байна.

Газар тариалан

2021 онд 19 сумын 377 иргэн, аж ахуйн нэгжээс үр тариа 10279 га, малын тэжээл 2808 га, тосны ургамал 150 га, төмс 275 га, хүнсний ногоо 153 га, жимс, жимсгэнэ 62 га-д тариалах захиалга авч, нэгтгэн салбарын яаманд хүргүүллээ.

Улаан буудай тариалдаг 7 сумын иргэн, аж ахуйн нэгжээс үр, хор, бордоо, шатахууны захиалгыг авч байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд Байгаль орчин

Ойн цэвэрлэгээг Могойн гол-Тээлийн Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын Бууралхангай нөхөрлөлийн хамгаалалттай ойн талбайд хамаарах “Бэржин” нэртэй газарт зохион байгуулж буй ойн цэвэрлэгээний ажилд Булган сумын 10 нөхөрлөлийн 85 гишүүд 78 машин техниктэй оролцон 3 дахь жилдээ ойн цэвэрлэгээг жишиг байдлаар зохион байгуулж, нийт 8 га талбай цэвэрлэсэн байна.

Нийт 240 машин цэвэрлэгээний мод Эрдэнэбулган суманд оруулан ойн цэвэрлэгээнээс гарсан модыг зах зээлийн үнээс 50 хувь хямдаар буюу 120-150 мянган төгрөгийн үнээр иргэдэд нийлүүлснээр аймгийн нэг өрхөд 150 мянган төгрөгийн дэмжлэгийг, нийт 240 өрхөд 36 орчим сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Ойн цэвэрлэгээний модноос нийт 40 орчим сая төгрөгийн орлого орсон ба нөхөрлөлийн 85 гишүүн өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна.

Цаг агаарын урьдчилсан мэдээг Мэдээлэл үйлчилгээний хэлтсээс 12 цагаар болон нэг, тав хоногоор өдөр бүр гаргаж тус бүр 31 удаа, 7 хоногийн урьдчилсан төлөвийг 4

удаа, сарын урьдчилсан төлөвийг 1 удаа, хүйтний улирлын урьдчилсан төлөвийг 1 удаа гаргаж олон нийтийн сүлжээ болон телевиз, arkhangai.tsag-agaar.gov.mn сайтад байршуулж, 7 хоногийн урьдчилсан төлөв мэдээг бичгээр холбогдох байгууллагуудад /ЗДТГ, ХХААГ, Авто тээврийн газар, ОБГ, Эрдэнэбулган сумын ЗДТГ, ЭМГ/-д хүргэж үйлчилсэн. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахаар аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх зорилготой “Анхааруулга, Сэрэмжлүүлэх, Урьдчилан сэргийлэх мэдээ” гаргах нөхцөл бүрдээгүй. Тус хэлтсээс “Архангай аймгийн цаг араарын урьдчилсан мэдээ/forecast/” page хуудсанд аймгийн хэмжээний сум бүрийн 3 хоногийн урьдчилсан мэдээг өдөр бүр байршуулан, ард иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэж байна.

Хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ

Хүнсний нөөцийн судалгааг 7 хоногт 2 удаа ирүүлэх тоот хүргүүлж, судалгааг нэгтгэн, ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ болон аймгийн онцгой комиссоод хүргүүлж байна. Сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 353.7 тн буюу 28 хоног, гурил 287.8 тн буюу 38 хоног, гоймон 36.8 тн буюу 3 хоног, будаа 72.7 тн буюу 19 хоног, сахар 59.6 тн буюу 24 хоног, ургамлын тос 22.6 тн буюу 13 хоног, давс 26.6 тн буюу 67 хоног, ундны ус 23.8 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 6.3 тн буюу 5 хоног, төмс 125.9 тн буюу 47 хоног, хүнсний ногоо 21.7 тн буюу 2 хоног, өндөг 0.39 тн буюу 6 хоногийн нөөцтэй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан А/225, А/379 тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, www.teeverzuuch.mn сайтад хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийн захиалга үүсгэж байна. Одоогийн байдлаар 724 тээвэрлэлтэд захиалга үүсгэсэн байна.

1-р сарын 14-нд ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-т орон нутагт бэлтгэгдэж, нөөцөлсөн мах бэлтгэлийн судалгааг хүргүүлэв. Аймгийн хэмжээнд 582 тн мах бэлтгэгдэж, нөөцөлсөн байна.

Аймгийн хэмжээнд модон эдлэлийн - 52, оёмол бүтээгдэхүүний - 43, барилгын материалын - 28, арьс шир эдлэх - 25, эсгий, ноос боловсруулах - 17, бусад - 56 нийт 221 жижиг үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж 399 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Барилга, дэд бүтэц

Сумдын барилга байгууламжийн хувийн хэрэг, нэгж талбарын хувийн хэргийг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн санд оруулах ажлын хуваарийг 2021 оны 01 дүгээр сарын 08-наас 03 сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд гаргаж энэ сарын 19-21-ний өдрүүдэд Булган суманд ажиллаж 6 барилгыг шинээр хувийн хэрэгжүүлж, 20 барилгын мэдээллийг дэд сангийн хүснэгтээр мэдээллийг авч боловсруулсан, 435 нэгж талбарын хувийн хэргийг цахимжуулж газрын кадастрын мэдээллийн санд оруулсан.

Хаягийн мэдээллийн системд хаягийг Засгийн газрын 325 дугаар тушаалд нийцсэн эсэхийг тулган шалгах ажлыг бүх сумдад хийж эхлээд байна.

1-р сард аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн өргөтгөл шинэчлэлийн засварын ажил, иргэн Гэрэлтийн үйлчилгээний амины орон сууцанд аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж барилга угсралтанд хүлээн авах комисс ажиллуулсан. 2020-2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 23 барилга угсралт, их засварын ажлын жагсаалтыг гаргаж аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст газрын 34 тоотгоор хүргүүлсэн.

Архангай аймагт 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр 300.0 сая төгрөгийн өртөг бүхий 19 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнээс 1-р сард:

-2021 онд хэрэгжүүлэх 19 төсөл арга хэмжээний хэмжилт хийж, зургийн даалгавар боловсруулсан.

-Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн 1 их засварын ажил, болон хувийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан 4 барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авах комисс ажиллуулсан.

-Булган, Төвшрүүлэх сумдын одоо ашиглагдаж байгаа барилгуудын хувийн хэрэгт баяжилт хийж, инженерийн шугам сүлжээг мэдээллийн санд оруулсан.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----